



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 72

Арвайхээр

Согтууруулах ундаа худалдах, түүгээр
үйлчлэх цэгийн талаар авах
арга хэмжээний тухай

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4.3 дахь заалтыг үндэслэн
ТОГТООХ нь:

1. "Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хяналт тавих журам"-ыг нэгдүгээр, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн загвар, санамж, гэрээний маягтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрхи журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Тогтохсүрэн/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү журмыг 2016 оны 01-р сарын 01-ний өдрөөс эхлэн аймгийн нийт нутаг дэвсгэрт мөрдүүлж, тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2005 оны 79 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



ДАРГА

Г.ГАНБОЛД

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны
10 дугаар сарын 22-ны өдрийн 78 дугаар
тогтоослын нэгдүгээр хавцралт



СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

1. Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Зорилт

1.1. Энэхүү журмын зорилт нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10, 16.2.5, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4.3, Иргэний хуулийн 26.8, 189 дүгээр заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргаас согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгүүдэд тусгай зөвшөөрлийг хэрхэн олгох, хүчингүй болгох, түүнд хяналт тавих, зэрэг арга хэмжээ авах үйл ажиллагааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Үйлчлэх хүрээ

2.1. Энэхүү журам нь Өвөрхангай аймгийн нийт нутаг дэвсгэрт үйлчилнэ.

3 дугаар зүйл. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хяналт тавих тухай хууль, тогтоомж

3.1. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хяналт тавих тухай хууль тогтоомж нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Монгол Улсын Иргэний хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиудын үйлчлэлийг хангана.

3.2. Энэ журамд заагдаагүй боловч согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хяналт тавихтай холбогдсон бусад харилцааг зохицуулахад холбогдох хуулийн заалтыг дагаж мөрдөнө.

3.3. Журамд хэрэглэгдэх нэр томъёог холбогдох хууль, тогтоомжид зааснаар ойлгоно.

2. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, өөрчлөх

4 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл олгох.

4.1. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг тухайн

нутаг дэвсгэрийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын болон аймгийн орон тооны бус зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн аймгийн Засаг дарга олгоно.

4.2. Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг

4.2.1 Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл /Хуулийн этгээд бол байгууллагын тамга тэмдэг бүхий албан бичиг/

4.2.2.Тусгай зөвшөөрөл хүсэгчийн иргэний үнэмлэхний хуулбар /хуулийн этгээдийн гэрчилгээний хуулбар/

4.2.3.Худалдаа, үйлчилгээний цэгийн гадна дотор талын дүрст зураг

4.2.4.Тохирлын гэрчилгээний хуулбар

4.2.5.Тусгай зөвшөөрлийг сунгах гэж байгаа бол оршин байгаа газрын багийн Засаг дарга болон Цагдаагийн байгууллагын захиргааны зөрчлийн талаархи тодорхойлолт зэргийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд ирүүлнэ.

4.3. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын чиг үүрэг

4.3.1. Тухайн нутаг дэвсгэртээ согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоо, байршлыг тогтоох

4.3.2. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг олгоход санал дүгнэлт гаргах эрх бүхий орон тооны бус ажлын хэсэг /эрх бүхий улсын байцаагч, цагдаагийн хэсгийн төлөөлөгч, иргэн, олон нийтийн байгууллагын төлөөлөл/ томилох, түүний ажиллах журмыг баталж, мөрдүүлэх

4.3.3. Тухайн хүсэлт ирүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийн оршин буй газрын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дэргэдэх орон тооны бус ажлын хэсэг нь МХЕГ-аас гаргасан стандарт, холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу тусгай зөвшөөрлийн шаардлага хангасан эсэхэд дүгнэлт гаргана.

4.3.4. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь тухайн цэгийн орчим оршин амьдардаг 50-иас доошгүй иргэдийн дунд түүвэр аргаар санал асуулга явуулан, иргэдийн олонхи зөвшөөрсөн тохиолдолд хэлэлцүүлэг зохион байгуулж, дүнг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэж, санал асуулгын дүнгийн тогтоол, ажлын хэсгийн дүгнэлтийн хамт аймгийн Засаг даргад хүргүүлнэ.

4.4. Аймгийн Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлийн чиг үүрэг

4.4.1.Тусгай зөвшөөрөл хүссэн иргэн, аж ахуйн нэгжийн өргөдөл, холбогдох материалыг хүлээн авч ажлын 14 хоногийн дотор хуралдаанаараа хэлэлцэж, дараах шийдвэрийг гаргана

4.4.2.Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангасан гэж үзэж Тусгай зөвшөөрөл олгох саналыг дэмжих

4.4.3. Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангаагүй бол тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах, татгалзсан үндэслэлийг заасан хариуг бичгээр хүргүүлэх

4.4.4. Тусгай зөвшөөрлийн эзэмшигчийн нэр, цэгийн нэр өөрчлөх хүсэлтийг шийдвэрлэх

4.4.5. Тусгай зөвшөөрлийн түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэх

4.5. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилэх тусгай зөвшөөрлийг олгоход аймгийн Засаг дарга захирамж гаргана. Тусгай зөвшөөрлийг аймгийн Засаг даргын захирамжийг үндэслэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсээс "Гэрчилгээ" хэлбэрээр хэвлэн, баталгаажуулж олгоно. /Журмын 1-р хавсралт/

4.6. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ авсан иргэн, аж ахуйн нэгж нь оршин суугаа газрын /сумын/ Засаг даргатай гэрээ байгуулж, сум, багийн Засаг даргаас гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана. /Журмын 2-р хавсралт/

4.7. Тусгай зөвшөөрлийг сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохдоо Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг баримтлан, аймгийн Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлийн саналын дагуу аймгийн Засаг дарга шийдвэрлэнэ.

4.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-д заасны дагуу тусгай зөвшөөрлөө бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах хэлбэрээр шилжүүлж үл болно.

4.9. Тусгай зөвшөөрөл бүхий худалдаа, үйлчилгээний цэгийг бусад иргэн, хуулийн этгээд шилжүүлэн /бэлэглэх, худалдах, худалдан авах гэрээний дагуу/ авч үйл ажиллагааг үргэлжлүүлэх бол дээрх журамд тавигдах шаардлагын дагуу холбогдох баримт, материалыг бүрдүүлж тусгай зөвшөөрлийг шинээр авна.

5 дугаар зүйл. Аймгийн Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлийн эрх, үүрэг

5.1. Тусгай зөвшөөрлийн орон тооны бус аймгийн зөвлөлийг аймгийн Засаг дарга ахлан, бүрэлдэхүүнд нь аймгийн ЗДТГазрын Хууль зүйн хэлтсийн дарга, Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга, Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын дарга, Мэргэжлийн хяналтын газрын дарга, Эрүүл мэндийн газрын дарга, Татварын хэлтсийн дарга, Стандартчилал хэмжил зүйн хэлтсийн дарга нар ажиллах бөгөөд нарийн бичгийн дарга нь аймгийн ЗДТГазрын Хууль зүйн хэлтсийн тусгай зөвшөөрөл

хариуцсан мэргэжилтэн байна.

5.2. Зөвлөл нь тусгай зөвшөөрөлтэй холбоотой бүртгэл судалгааг хөтлөх.

5.3 Мэргэжлийн хяналтын байгууллагын гаргасан дүгнэлт болон Стандартчилал, хэмжил зүйн байгууллагын тохирлын гэрчилгээний олголтын байдалд хяналт тавих.

5.4 Гэрчилгээ, түүнийг дагалдах гэрээний эх загварыг гарган эрх бүхий байгууллагаар батлуулан, мөрдүүлэх.

5.5 Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтад дурьдагдсан албан тушаалтанд тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтэд хяналт тавихыг шаардах, тэдний илрүүлсэн зөрчлийн мөрөөр арга хэмжээ авч холбогдох шийдвэрийг гаргуулах

5.6 Худалдаа, үйлчилгээний цэгт худалдаалагдаж буй согтууруулах ундааг чанарын шаардлага хангах эсэх талаар эрх бүхий байгууллагаар шинжилгээ хийлгэх, цэгүүдэд дүгнэлт гаргахад босго онооны хэмжээ хязгаарыг хэлэлцэн тогтоох

5.7. Орон тооны бус зөвлөлийн гишүүд нь хуралдаанд оролцох бүртээ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу төрийн албан тушаалтны хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж, ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаарх мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргах

5.8. Орон тооны бус зөвлөл нь бүрэлдэхүүнийхээ 50-аас дээш хувийн ирцтэйгээр хуралдах ба асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэж, саналын зөрүүтэй гишүүний саналыг хуралдааны тэмдэглэлд тусгах

5.9. Сум болон бусад эрх бүхий байгууллагын саналыг үндэслэн худалдаа, үйлчилгээний цэгүүдэд хяналт, шалгалтыг зохион байгуулах, аттестатчилал явуулах

6 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгоход тавигдах тусгай шаардлага

6.1. Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах цэгийн ажиллах цагийн хуваарийг аймгийн Засаг дарга баталж мөрдүүлнэ.

6.2. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэг нь стандарт шаардлага хангаагүй, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол, ажлын хэсгийн дүгнэлтээр татгалзсан хариу ирүүлсэн, аймгийн орон тооны бус зөвлөлөөс тогтоосон босго оноонд хүрээгүй бол аймгийн Засаг даргаас тусгай зөвшөөрлийг олгохгүй.

6.3. Монгол улсын Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан тусгай зөвшөөрлийн зөвшөөрөгдсөн цэгээс бусад

- Төрийн болон төрийн бус байгууллагын албан байр,

- Согтууруулах ундаагаар үйлчлэх зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээс бусад аж ахуйн нэгжийн албан болон үйлдвэрлэлийн байр;
- Хүүхдийн цэцэрлэг, бүх шатны ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, сувиллын газар;
- Оюутан, сурагчдын хичээлийн болон нийтийн дотуур байр;
- Нийтийн орон сууцны орц /1 давхар/, хонгил;
- Гудамж, талбай, цэцэрлэг;
- Авто тээврийн буудал, зогсоол
- Хүнсний болон барааны захад архи согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэхийг хориглоно.

6.4. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэг нь гадна талдаа гэрэлтүүлэгтэй, тусгай теле-камержуулалттай /гадна, дотор/ байх ба камерын бичлэгийг архивын хадгалалтын стандартаар сан хөмрөг үүсгэн хадгална.

7 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага

7.1. Холбогдох хууль, дүрэм, журмыг удаа дараа /3 удаа/ зөрчсөн тохиолдолд аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газар болон Мэргэжлийн хяналтын газрын санал дүгнэлтийг үндэслэн иргэн, аж ахуйн нэгжийн Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

7.2. Энэхүү журмыг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, эрх бүхий албан тушаалтанд аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

8 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ олгох, гэрээ байгуулах

8.1. Аймгийн Засаг дарга согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгохдоо энэхүү журмаар батлагдсан гэрчилгээний загвараар олгоно.

8.2. Сумын Засаг дарга иргэн, аж ахуйн нэгжтэй тусгай зөвшөөрөл эзэмших зөвшөөрлийн гэрээ байгуулна.

8.3. Гэрээний үүргээ биелүүлээгүй /3 удаа/ иргэн, аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, түдгэлзүүлэх тухай сумын Засаг даргын саналыг аймгийн Засаг даргад хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

9 дүгээр зүйл. Бусад зүйл.

9.1. Энэхүү журам, стандартын ерөнхий шаардлагыг хангасан иргэн, аж ахуй нэгжид олгох тусгай зөвшөөрлийг Монгол улсын Улсын тэмдэгтийн хураамжийн хуулийн дагуу хураамжаа төлсөн тохиолдолд олгоно.

9.2.Тусгай зөвшөөрлийг хэвлэх, олгохтой холбогдсон бусад зардлыг аймгийн ЗДТГазраас санхүүжүүлнэ

-----oOo-----



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны
10 дугаар сарын 25-ны өдрийн 2 дугаар
тогтоолын хоёрдугаар хавсралт

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

_____ он _____ сар _____ өдөр Дугаар _____ Арвайхээр
/огноо/ /ЗД-ын захирамж, МХГ-ын газрын дүгнэлт/

ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН НЭР: _____

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨРӨЛ: _____

ЭЗЭМШИГЧ ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН НЭР, ХАЯГ: _____

ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ НУТАГ ДЭВСГЭР: _____

ГЭРЧИЛГЭЭ _____ ОН _____ САР _____ ӨДӨР ХҮРТЭЛ ХҮЧИНТЭЙ.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

/Гэрээний загвар/

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИХ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЭЭ

/Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх/

_____ хот

№

20__оны__дугаар

аймаг,сум,дүүрэг

сарын__-ны өдөр

Тусгай зөвшөөрөл эзэмшихийг /худалдаа, үйлчилгээний эрх аль нь болохыг доогуур нь зурна/-ыг зөвшөөрөх энэхүү гэрээг нэг талаас _____

_____ хаягт

амьдрах _____/эцгийн

нэр, нэр/ _____ /тоот регистртэй, /цаашид "Сумын Засаг дарга" гэнэ/,

нөгөө _____ талаас

_____ хаягт оршин

суух _____/Овог нэр,

Хуулийн этгээдийн нэр/ _____ /тоот регистертэй, /цаашид "Эрх авагч"

гэнэ/ нар цаашид /хамтдаа талууд гэнэ/ Монгол Улсын Аж ахуйн үйл ажиллагааны

тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 9 дүгээр зүйл, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн

хурлаар батлагдсан 20...__оны__дугаар журмыг үндэслэн харилцан

тохиролцож дор дурдсан нөхцөлөөр энэхүү гэрээг байгуулж байна.

1. Нийтлэг үндэслэл

1.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Монгол улсын Архидан согтуурахтай тэмцэх тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргаас гаргасан бодлого шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллана.

1.2. Энэхүү гэрээгээр талууд орчны эрүүл ахуй, нийгмийн хэв журам сахих, хөршийн эрхийг хүндэтгэх зэрэг харилцаанд хяналт тавих, харилцан хамтарч ажиллахад чиглэнэ.

1.3. Худалдаа, үйлчилгээ явуулж буй цэгийн эрх эзэмшигч нь оршин суугаа газрын сумын Засаг даргатай энэхүү гэрээг байгуулах, шаардлагатай тохиолдолд гэрээ байгуулах, хяналт тавих эрхийг багийн Засаг даргад шилжүүлж болно.

2. Сумын Засаг даргын эрх, үүрэг

2.1. Энэхүү гэрээгээр эрх эзэмшигчийн хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж буй хяналт тавих, эрх бүхий байгууллагын шийдвэрээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийг шаардах, нийтийн хамарсан арга хэмжээ, дайчилгаанд оролцуулах асуудлыг бүрэн хариуцна.

2.2. Эрх эзэмшигчийн эрх зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй нөхцөл байдалд эрх зүйн туслалцаа үзүүлж, хүсэлт гомдлыг эрх бүхий байгууллагад уламжлах

2.3. Эрх эзэмшигчийн үйл ажиллагааны талаархи санал дүгнэлтийг мэргэжлийн хяналтын эрх бүхий байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх

2.4. Эрх бүхий /Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, аймгийн Засаг даргаас томилсон ажлын хэсэг/ байгууллагатай хамтран хяналт, шалгалтыг зохион байгуулах

3. Эрх эзэмшигчийн эрх үүрэг

3.1. Холбогдох хууль тогтоомжид заасан эрх үүргийг эдлэхийн зэрэгцээ холбогдох хууль журам, стандарт, худалдаа, үйлчилгээний цагийн хуваарийг журмын дагуу мөрдөнө.

3.2. Эрх эзэмшигч нь гэрчилгээний эх хувийг худалдаа, үйлчилгээний цэгт олон нийт ил тод харагдахаар байршуулж, эрх бүхий этгээдэд саадгүй үзүүлэх ба эрхээ эдлэхдээ гэрчилгээг үрэгдүүлэх, хууль бусаар олшруулах, зориулалтыг өөрчлөхгүй, гэмтээхгүй байх үүрэгтэй.

3.3. Эрх эзэмшигч нь гэрчилгээ эзэмших эрхээ өөрийн нэрээр бүрэн эдэлнэ.

3.4. Худалдаа, үйлчилгээний цэгийн орчны эрүүл ахуй, стандартыг чанд мөрдөж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, орон нутгийн засаг захиргааны байгууллагаас зохион байгуулж буй нийтийг хамарсан арга хэмжээнд идэвхитэй оролцоно.

4. Бусад заалт

4.1. Энэхүү гэрээ нь гуравдагч этгээдэд хамаарахгүй.

4.2. Энэхүү гэрээний нөхцөл, заалттай холбоотой маргаан гарвал талууд аль болох хэлэлцээ хийх аргаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд эс эвлэрэвэл Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

4.3. Энэхүү гэрээнд талууд гарыг үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болно.

4.4. Энэхүү гэрээг _____ оны _____ сарын _____ -ны өдрөөс адил хүчинтэй гурван хувь үйлдэж талууд тус бүрт нэг хувь, аймгийн орон тооны бус зөвлөлд нэг эх хувь хадгалагдана.